



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын хураангуй тайлан

Аудитын код: СЭА-2026/009/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](mailto:www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх

Утас: 7036-3040

Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор:

Ц.Отгонбаяр

Утас: 7036-3036

Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn

Аудитор:

Ц.Уртнасан

Утас: 7036-2442

Цахим хаяг: urtaa6969@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.08.15 № СТА-2026/009/НА-СТА-ОНӨҮГ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Дотоод хяналтыг зохион байгуулаагүйгээс тайлант онд албан хаагчдаас авах 18,400.3 мянган төгрөгийн, түрээсийн 11,832.5 мянган төгрөгийн авлагыг нэмж үүсгэсэн,
- Өмнөх онд олон улсын худалдааны төвийн дээврийг засах зориулалтаар худалдан авсан 11,290.9 мянган төгрөгийн усны хамгаалалттай тосон будгийг хангамжийн материалын дансанд үлдэгдлээр тайлагнан цаашид ашиглах шаардлагагүй хөрөнгө нөөцөлсөн,
- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар баригдсан нийтийн ариун цэврийн барилгын зориулалтыг өөрчлөн, түрээсийн гэрээ байгуулалгүйгээр Чунас агуйт ХХК-д эзэмшүүлж, ашиглуулсан,

4326050334

- Татварын авлага, өр төлбөрийг зөрүүтэй тусгасан алдааг залруулж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант оны авлага өр төлбөр зөрүүтэй илэрхийлэгдсэн,

Аудитаар илэрсэн дээрх зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 5 дугаар зүйлийн 5.5, 28 дугаар зүйлийн 28.3, 67 дугаар зүйлийн 67.1, 67.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.6, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн *"Нийцсэн бөгөөд зохистой байх"* гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Өргөн Сэлэнгэ ОНӨААТҮГ-ын захирал Э.Эрдэнэбаатар нь Сүхбаатар сумын Засаг даргатай 5 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан боловч гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд нийт 1,554,639.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,770,301.5 мянган төгрөгийг зарцуулан 215,661.8 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 2,429,599.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,618,133.0 мянган төгрөгийн зарцуулан, 188,533.9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Аймгийн Нийгмийн даатгалын газар, Татварын газар нь тус байгууллагын харилцах дансыг НДШ-ийн болон татварын өр төлбөрийг барагдуулахаар хаасан боловч оны эцэст НДШ-ийн 105,063.1 мянган төгрөг, татварын 178,765.3 мянган төгрөгийн өр төлбөр тус тус тайлагнагдсан байна. Тус байгууллага нь тайлант оны эцэст гэрэл цахилгаан болон халаалтын төлбөрөө төлөх санхүүгийн чадамжгүйд хүрч хязгаарлалт хийгдэх, таслах мэдэгдэл ирүүлсэн тул хувь хүнээс 46,700.0 мянган төгрөгийн хүүгүй барьцаагүй 2 сарын зээл авч төлбөрийг барагдуулсан байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.БАТМӨНХ



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт                                | 2024 оны 12-р сарын 31  | 2025 оны 12-р сарын 31  |
|---------------|---|-------------------------|-------------------------|
| <b>1</b>      | <b>ХӨРӨНГӨ</b>                          |                         |                         |
| <b>1.1</b>    | <b>Эргэлтийн хөрөнгө</b>                |                         |                         |
| 1.1.1         | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө         | 36,197,481.66           | 10,786,081.11           |
| 1.1.2         | Дансны авлага                           | -                       | -                       |
| 1.1.3         | Татвар, НДШ-ийн авлага                  | 9,921,443.22            | 9,921,443.22            |
| 1.1.4         | Бусад авлага                            | 98,777,319.73           | 126,308,577.57          |
| 1.1.5         | Бусад санхүүгийн хөрөнгө                | 0                       | 0                       |
| 1.1.6         | Бараа материал                          | 426,383,838.47          | 492,559,005.87          |
| <b>1.1.20</b> | <b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>          | <b>571,280,083.08</b>   | <b>639,575,107.77</b>   |
| <b>1.2</b>    | <b>Эргэлтийн бус хөрөнгө</b>            | <b>0</b>                | <b>0</b>                |
| 1.2.1         | Үндсэн хөрөнгө                          | 8,066,764,401.12        | 8,138,427,631.06        |
| 1.2.2         | Биет бус хөрөнгө                        | 1,476,029.99            | 1,166,666.64            |
| 1.2.10        | <b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>      | <b>8,068,240,431.11</b> | <b>8,139,594,297.70</b> |
| <b>1.3</b>    | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>               | <b>8,639,520,514.19</b> | <b>8,779,169,405.47</b> |
| <b>2</b>      | <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>          | <b>0</b>                | <b>0</b>                |
| 2.1.1.1       | Дансны өглөг                            | 19,869,957.92           | 239,279,764.74          |
| 2.1.1.2       | Цалингийн өглөг                         | 0                       | 4,730,245.54            |
| 2.1.1.3       | Татварын өр                             | 170,599,111.44          | 178,765,368.19          |
| 2.1.1.4       | НДШ-ийн өглөг                           | 9,186,631.32            | 105,063,105.65          |
| 2.1.1.13      | <b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b> | <b>199,655,700.68</b>   | <b>527,838,484.12</b>   |
| <b>2.2</b>    | <b>ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН</b>            | <b>199,655,700.68</b>   | <b>527,838,484.12</b>   |
| 2.3.8         | Эздийн өмчийн бусад хэсэг               | 11,515,956,486.72       | 11,515,956,486.72       |
| 2.3.9         | Хуримтлагдсан ашиг                      | -3,078,044,161.07       | -3,264,625,565.37       |
| <b>2.3.11</b> | <b>Эздийн өмчийн дүн</b>                | <b>8,439,864,813.75</b> | <b>8,251,330,921.35</b> |
| <b>2.4</b>    | <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>   | <b>8,639,520,514.19</b> | <b>8,779,169,405.47</b> |

## **2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

| <b>Үзүүлэлт</b>   | <b>2024 оны 12-р сарын 31</b> | <b>2025 оны 12-р сарын 31</b> |
|---|-------------------------------|-------------------------------|
| Борлуулалтын орлого (цэвэр)                                   | 1,320,126,443.8               | 2,429,599,208.8               |
| Бараа бүтээгдэхүүний борлуулалтын орлого                      | 1,320,126,443.8               | 1,540,607,020.8               |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого                             | 367,688.2                     | 888,992,188.0                 |
| <b>Нийт ашиг ( алдагдал)</b>                                  | <b>1,320,494,132.0</b>        | <b>2,429,599,208.8</b>        |
| Ерөнхий ба удирдлагын зардал                                  | 1,668,147,800.7               | 2,610,332,101.2               |
| Бусад зардал  | 7,383,900.0                   | 7,801,000.0                   |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)                    | (35,189,640.6)                | -                             |
| <b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>                  | <b>(390,213,746.2)</b>        | <b>(188,533,892.4)</b>        |
| <b>Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b> | <b>(390,227,209.3)</b>        | <b>(188,533,892.4)</b>        |
| <b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>                   | <b>(390,227,209.3)</b>        | <b>(188,533,892.4)</b>        |
| <b>Орлогын нийт дүн</b>                                       | <b>(390,227,209.3)</b>        | <b>(188,533,892.4)</b>        |
| Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)                   | -                             | -                             |

## **2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| <b>№</b> | <b>ҮЗҮҮЛЭЛТ</b>                              | <b>Эздийн өмчийн бусад хэсэг</b> | <b>Хуримтлагдсан ашиг</b> | <b>Нийт дүн</b>         |
|----------|--|----------------------------------|---------------------------|-------------------------|
| 1        | <b>2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл</b>   | 10,922,786,858.72                | -285,864,463.63           | 8,236,922,395.09        |
| 3        | <b>Залруулсан үлдэгдэл</b>                   | 10,922,786,858.72                | -285,864,463.63           | 8,236,922,395.09        |
| 4        | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)          |                                  | -390,227,209.34           | -390,227,209.34         |
| 6        | Өмчид гарсан өөрчлөлт                        | 593,169,628.48                   |                           | 593,169,628.48          |
| 9        | <b>2024 оны 01 -р сарын 01 -ний үлдэгдэл</b> | <b>11,515,956,487.20</b>         | <b>-3,076,091,672.97</b>  | <b>8,439,864,814.23</b> |
| 11       | <b>Залруулсан үлдэгдэл</b>                   | <b>11,515,956,487.20</b>         | <b>-3,076,091,672.97</b>  | <b>8,439,864,814.23</b> |
| 14       | Өмчид гарсан өөрчлөлт                        |                                  | -                         | -                       |
| 13       | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)          |                                  | (188,533,892.40)          | (188,533,892.40)        |
| 17       | <b>2024 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл</b> | <b>11,515,956,487.20</b>         | <b>-3,264,625,565.37</b>  | <b>8,251,330,921.83</b> |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

|            | ҮЗҮҮЛЭЛТ   | 2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл |
|------------|--|-------------------------------------|-------------------------------------|
| 1          | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ                          |                                     |                                     |
| 1.1        | Мөнгөн орлогын дүн (+)   | 1,451,437,158.17                    | 1,713,257,325.48                    |
| 1.1.1      | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого                   | 800,182,258.17                      | 1,037,158,825.48                    |
| 1.1.5      | Татаас, санхүүжилтийн орлого                                   | 651,254,900.00                      | 673,896,000.00                      |
| <b>1.2</b> | <b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>                                 | <b>1,437,390,669.19</b>             | <b>1,774,494,315.58</b>             |
| 1.2.1      | Ажиллагчдад төлсөн   | 312,941,828.82                      | 625,704,128.92                      |
| 1.2.2      | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн                         | 76,071,360.04                       | 67,632,699.02                       |
| 1.2.3      | Бараа материал худалдан авахад төлсөн                          | 271,779,001.78                      | 752,005,079.22                      |
| 1.2.4      | Ашиглалтын зардалд төлсөн                                      | 440,384,524.13                      | 173,290,660.48                      |
| 1.2.5      | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн          | 50,270,473.23                       | 81,342,695.32                       |
| 1.2.7      | Татварын байгууллагад төлсөн                                   | 235,751,050.90                      | 69,085,075.50                       |
| 1.2.9      | Бусад мөнгөн зарлага   | 50,192,430.29                       | 5,433,977.12                        |
| <b>1.3</b> | <b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>      | <b>14,046,488.98</b>                | <b>(61,236,990.10)</b>              |
| 2.1        | Мөнгөн орлогын дүн (+)   | 134,631.16                          | -                                   |
| 2.1.7      | Хүлээн авсан ногдол ашиг                                       | 134,631.16                          | -                                   |
| 2.2        | Мөнгөн зарлагын дүн (-)  | 12,449,500.04                       | 10,874,410.00                       |
| 2.2.1      | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн                            | 12,449,500.04                       | 10,874,410.00                       |
| 2.3        | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (12,314,868.88)                     | (10,874,410.00)                     |
| 3.1        | Мөнгөн орлогын дүн (+)   | -                                   | 70,700,000.00                       |
| 3.1.1      | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан            | -                                   | 70,700,000.00                       |
| 3.2        | Мөнгөн зарлагын дүн (-)  | -                                   | 24,000,000.00                       |
| 3.2.1      | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө                   | -                                   | 24,000,000.00                       |
| 3.3        | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн         | -                                   | 46,700,000.00                       |
| 4.1        | <b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>                                | <b>1,731,620.10</b>                 | <b>(25,411,400.10)</b>              |
| 5          | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>        | <b>34,465,861.56</b>                | <b>36,197,481.66</b>                |
| 6          | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>       | <b>36,197,481.66</b>                | <b>10,786,081.11</b>                |
|            | <b>БЦМГ(1.3+2.3+3.3+4)</b>                                     | <b>1,731,620.10</b>                 | <b>(25,411,400.10)</b>              |
|            | <b>БЦМГ(6-5)</b>   | <b>1,731,620.10</b>                 | <b>(25,411,400.10)</b>              |
|            | Зөрүү  | 0                                   | 0                                   |

## **2.5 Эдийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

| <b>Орлого, Зардлын зүйл</b>         | <b>Төлөвлөгөө</b>   | <b>Гүйцэтгэл</b>    | <b>Зөрүү</b>      | <b>Хувь</b>  |
|-------------------------------------|---------------------|---------------------|-------------------|--------------|
| <b>I. НИЙТ ОРЛОГО</b>               | <b>1,554,639.70</b> | <b>2,429,599.10</b> | <b>874,959.40</b> | <b>156.3</b> |
| Үндсэн үйл ажиллагааны орлого       | 874,888.60          | 860,855.90          | (14,032.70)       | 98.4         |
| Татаас санхүүжилтээс                | 679,751.10          | 679,751.10          | 0.00              | 100.0        |
| үнэ төлбөргүй хүлээн авсан орлого   | 0.00                | 888,992.10          | 888,992.10        |              |
| <b>IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>       | <b>1,770,301.50</b> | <b>2,618,133.00</b> | <b>-847,832</b>   | <b>147.9</b> |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил  | 700,000.00          | 737,490.50          | -37,491           | 105.4        |
| Ажил олгогчоос НДШ                  | 78,350.70           | 86,445.70           | -8,095            | 110.3        |
| Бичиг хэрэг                         | 6,000.00            | 5,510.50            | 490               | 91.8         |
| Гэрэл цахилгаан                     | 411,889.30          | 400,532.80          | 11,357            | 97.2         |
| Түлш, халаалт                       | 101,136.00          | 106,297.00          | -5,161            | 105.1        |
| Тээвэр (шатахуун)                   | 73,451.00           | 66,046.30           | 7,405             | 89.9         |
| Шуудан, холбоо, интернет            | 5,840.00            | 5,388.00            | 452               | 92.3         |
| Хог, Цэвэрлэгээ                     | 19,360.00           | 21,780.40           | -2,420            | 112.5        |
| Цэвэр, бохир ус                     | 48,000.00           | 49,342.20           | -1,342            | 102.8        |
| Дотоод албан томилот                | 4,000.00            | 3,930.00            | 70                | 98.3         |
| Мэргэжлийн үйлчилгээний зардал      | 61,549.70           | 60,953.50           | 596               | 99.0         |
| Тээврийн хэрэгслийн сэлбэг хэрэгсэл | 27,299.00           | 15,341.80           | 11,957            | 56.2         |
| Материал хангамж                    | 147,703.90          | 175,392.90          | -27,689           | 118.7        |
| Урсгал засвар                       | 3,000.00            | 17,200.60           | -14,201           | 573.4        |
| Шагнал урамшуулал тэтгэмж           | 3,830.00            | 3,940.00            | -110              | 102.9        |
| Сургалт зардал                      | 500.00              | 420.00              | 80                | 84.0         |
| Бусад зардал банкны шимтгэл         | 0                   | 1,949.80            | -1,950            | 0.0          |
| Тэмцээн уралдаан                    | 2,500.00            | 0.00                | 2,500             | 0.0          |
| Алдинг торгууль                     | 0.00                | 1,076.00            | -1,076            | 0.0          |
| Бусад зардал                        | 5,000.00            | 6,725.00            | -1,725            | 134.5        |
| Албан татвар төлбөр хураамж         | 70,891.90           | 21,573.20           | 49,319            | 30.4         |
| Бусад зардал                        | 0                   | 7,801.00            | -7,801            |              |
| Элэгдлийн зардал                    | 0                   | 822,995.80          | -822,996          | 0.0          |
| Ашиг алдагдал                       | -215,661.8          | -188,533.9          | 0                 | 0.0          |

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

### **5.1 Залруулга**

Аудитаар нийт **797,545.7** мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 3 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

*Залруулсан алдаа:*

- Өмнөх оны бараа материалын тайлангийн эцсийн үлдэгдлийн 420,000.0 мянган төгрөгийн материалыг дараа оны эхний үлдэгдэл болгож шилжүүлэлгүйгээр тайлагнасан.
- Санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл нь эд хариуцагчийн үндсэн хөрөнгийн тайлангийн эцсийн үлдэгдлээс 377,109.4 мянган төгрөгөөр илүү тайлагнагдсан.
- Санхүүгийн байдлын тайлангийн шатахууны эхний үлдэгдэл нь эд хариуцагчийн шатахууны тайлангийн эхний үлдэгдлээс 436.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

Дээрх алдаанууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”* гэсэн заалт болон НББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, НББОУС-2 *“Бараа материал”*, НББОУС-16 *“Үндсэн хөрөнгө”*, *“Үнэлгээ ба хуваарилалт”* батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Аудитаар нийт 742,807.7 мянган төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй ажиллах 41,523.7 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 701,284.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **41,523.7** мянган төгрөгийн материаллаг залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 30,176.6 мянган төгрөгөөр давсан тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

### **5.2 Албан шаардлага**

**5.2.1** Дотоод хяналтыг зохион байгуулаагүйгээс тайлант онд албан хаагчдаас авах 18,400.3 мянган төгрөгийн, түрээсийн 11,832.5 мянган төгрөгийн авлагыг нэмж үүсгэсэн байна.

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн *“Дотоод хяналт шалгалт”*, 67.1 дэх *“Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.”*, 67.2 дахь *“Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Дотоод хяналтыг зохион байгуулан шинээр авлага үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

**5.2.2.** Өмнөх онд олон улсын худалдааны төвийн дээврийг засах зориулалтаар худалдан авсан **11,290.9** мянган төгрөгийн усны хамгаалалттай тосон будгийг хангамжийн материалын дансанд үлдэгдлээр тайлагнан цаашид ашиглах шаардлагагүй хөрөнгө нөөцлөн худалдан борлуулж эргэлтэд оруулаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:”, 15.1.6 дахь “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шаардлагагүйгээр их хэмжээний бараа материалыг нөөцөлсөн зөрчлийг арилгаж, худалдан борлуулах замаар эдийн засгийн эргэлтэд оруулах албан шаардлага хүргүүлэв.

**5.2.3.** Сайхны хөтөлд орон нутгийн хөрөнгө оруулалтаар баригдсан нийтийн ариун цэврийн байгууламжийг зориулалтыг өөрчлөн, түрээсийн гэрээ байгуулалгүйгээр Э.Баярчимэг захиралтай Чунас агуйт ХХК-д мах шарах үйлчилгээ эрхлүүлэн эзэмшүүлж, ашиглуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д “Төрийн өөрийн өмчийг зориулалт бусаар захиран зарцуулах,.....”, 28 дугаар зүйлийн 28.3-д “Түрээсийн гэрээнд Иргэний хуулийн 105 дугаар зүйлд заасан нөхцөлөөс гадна эд хөрөнгө түрээслүүлэх хугацаа, төлбөр, нөхцөл, хугацаанаас өмнө цуцлах үндэслэл, үүсэх үр дагавар, түүнийг арилгах журмыг заавал тусгана.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах албан шаардлага хүргүүлэв.

**5.2.4** Өмнөх аудитаар өгөгдсөн татварын авлага, өр төлбөрийг зөрүүтэй тусгасан алдааг залруулж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант оны авлага, өр төлбөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.10-т “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасны дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

### **5.3. Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

## **1. Эд хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал:**

**5.3.1.** Тус байгууллагын эд хариуцагч Б.Алтанцэцэг нь шинээр томилогдсон Э.Энхмаатай ажил хүлээлцэх үедээ бараа материалын тооллогыг хийгээгүй зөвхөн үндсэн хөрөнгийн тооллого хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2. дахь “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:” 12.2.2 дахь “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед;” гэсэн заалттай нийцээгүй бөгөөд “Үнэлгээ ба хуваарилалт” баталж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эд хариуцагч солигдох үед бараа материалыг тоолж хүлээлцэж байх зөвлөмж хүргүүлэв.

## **2.Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:**

**5.3.2. Илрүүлэлт:** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй тайлант оны эцэст ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа нийт 701,284.0 мянган төгрөгийн анхны үнэтэй хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 дахь “ ... элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, НББОУС-16 “Үндсэн хөрөнгө” гэсэн заалтууд болон “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

1.2 Шийдвэрлэсэн нь: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох, актлах саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>2</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

# 1. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга   | Нийт алдаа |                  | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |                  | Үүнээс     |                  |              |     | Зөвлөмж |     |
|---|------------|------------------|-----------------------------------|-----|--------------------------|------------------|------------|------------------|--------------|-----|---------|-----|
|   | Тоо        | Дүн              | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн              | Залруулсан |                  | Залруулаагүй |     | Тоо     | Дүн |
|   |            |                  |                                   |     |                          |                  | Тоо        | Дүн              | Тоо          | Дүн |         |     |
| Бараа материалын эцсийн үлдэгдлийг дараа оны эхний үлдэгдэл болгож шилжүүлэлгүйгээр тайлагнасан   | 1          | 420,000.0        |                                   |     | 1                        | 420,000.0        | 1          | 420,000.0        |              |     |         |     |
| Санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл нь эд хариуцагчийн үндсэн хөрөнгийн тайлангийн эцсийн үлдэгдлээс зөрүүтэй тайлагнагдсан. | 1          | 377,109.4        |                                   |     | 1                        | 377,109.4        | 1          | 377,109.4        |              |     |         |     |
| Санхүүгийн байдлын тайлангийн шатахууны эхний үлдэгдэл нь эд хариуцагчийн шатахууны тайлангийн эхний үлдэгдлээс илүү тайлагнасан                        | 1          | 436.3            |                                   |     | 1                        | 436.3            | 1          | 436.3            |              |     |         |     |
| <b>Дүн</b>  | <b>3</b>   | <b>797,545.7</b> |                                   |     | <b>3</b>                 | <b>797,545.7</b> | <b>3</b>   | <b>797,545.7</b> |              |     |         |     |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                                   | Нийт зөрчил |          | Үүнээс        |     |                 |          |         |     |                                      |     |   |     |
|--|-------------|----------|---------------|-----|-----------------|----------|---------|-----|--------------------------------------|-----|---|-----|
|  | Тоо         | Дүн      | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |          | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|  |             |          | Тоо           | Дүн | Тоо             | Дүн      | Тоо     | Дүн | Тоо                                  | Дүн | Тоо   | Дүн |
| Төлбөр тооцоог хянаагүйгээс авлага, өглөг нэмэгдсэн. | 1           | 30,232.8 |               |     | 1               | 30,232.8 |         |     |                                      |     |   |     |
| Цаашид ашиглах шаардлагагүй хөрөнгө нөөцөлсөн        | 1           | 11,290.9 |               |     | 1               | 11,290.9 |         |     |                                      |     |   |     |

|   |          |                  |  |  |          |                 |          |                  |  |  |  |  |
|---|----------|------------------|--|--|----------|-----------------|----------|------------------|--|--|--|--|
| Нийтийн ариун цэврийн барилгыг зориулалтыг өөрчлөн түрээсийн гэрээ байгуулалгүйгээр ашиглуулсан.          | 1        | -                |  |  | 1        | -               |          |                  |  |  |  |  |
| Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр татварын авлага, өр төлбөрийг зөрүүтэй илэрхийлсэн. | 1        | -                |  |  | 1        | -               |          |                  |  |  |  |  |
| Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн талаарх саналыг холбогдох газарт хүргүүлээгүй.           | 1        | 701,284.0        |  |  |          |                 | 1        | 701,284.0        |  |  |  |  |
| Эд хариуцагч солигдох үед бараа материалын тооллого хийгээгүй.  | 1        | -                |  |  |          |                 | 1        | -                |  |  |  |  |
| <b>Дүн</b>  | <b>6</b> | <b>742,807.7</b> |  |  | <b>4</b> | <b>41,523.7</b> | <b>2</b> | <b>701,284.0</b> |  |  |  |  |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

**/мянган төгрөгөөр/**

| Зөрчлийн товч утга  | Нийт зөрчил |     | Үүнээс        |     |                 |     |         |     |
|---|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|   |             |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|   | Тоо         | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| <b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b> |             |     |               |     |                 |     |         |     |
| Шилэн дансны мэдээллийг 2 удаа хоцроосон                        | 1           | 0   |               |     |                 |     | 1       | 0   |
| <b>Дүн</b>  |             | -   |               |     |                 |     |         |     |

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо |                             |                    |                 | Санал дүгнэлтийн хэлбэр |                |       |                            |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
|   |                             | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |                    |                 | Зөрчилгүй               | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|   |                             |                          | Санал дүгнэлт гаргасан      | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй |                         |                |       |                            |
|   |                             |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |

| A | 1                      | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
|---|------------------------|---|---|---|---|---|---|---|----|
| 1 | Өргөн сэлэнгэ ОНӨААТҮГ | 1 | 1 |   |   |   | 1 |   |    |
| 2 | Төсөл, хөтөлбөр        |   |   |   |   |   |   |   |    |
| 3 | ЗГТС                   |   |   |   |   |   |   |   |    |
| 4 | ТТЗ                    |   |   |   |   |   |   |   |    |
| 5 | ТЕЗ                    |   |   |   |   |   |   |   |    |
|   | <b>НИЙТ</b>            |   |   |   |   |   |   |   |    |